

Аудитын код: САГ-2018/102/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор П.Амарсанаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
“Ньюбаланс Аудит” ХХК
Утас: 70145542 Цахим хаяг: newbalance_audit@yahoo.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Орлого, зардал, санхүүгийн тайлангийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	4
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	4
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
3	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
3.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	8
3.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
3.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
3.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.14 № 06/674
танай _____ -ны № _____ -т

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАРЬЯА "ГОРХИ МЭЛХИЙ ХАД"
УТУГ-ЫН ДАРГА Ц.НАНСАЛМАА
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа "Горхи мэлхий хад" УТУГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гаалийн ерөнхий газрын харьяа "Горхи мэлхий хад" УТУГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гаалийн ерөнхий газрын харьяа "Горхи мэлхий хад" УТУГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0314SAG13.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
870543
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус УТҮГ-ын дарга Ц.Нансалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг хэрэгжүүлж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ундэслэл, Аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ньюбаланс Аудит” ХХК-ийн аудитор Х.Бадмаанямбуу, аудиторын туслах П.Мөнхцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.



Аудитаар Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тус УТҮГ-ын даргын 2018 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн 03 дугаар албан бичгээр “Ньюбаланс Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Анх 2002 онд “Горхи мэлхий хад” УТҮГ нь Гаалийн ерөнхий газрын даргын 2002 оны 602 дугаар тушаалаар Сангийн яам, Гаалийн ерөнхий газрын ажилтнуудын ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлэх, амралтын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор байгуулагдсан байна.

Тэмдэглэлт баяр ёслолын үеэр Сангийн яам, Гаалийн ерөнхий газрын ажилтнууд 50.0 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр амардаг боловч сүүлийн жилүүдэд амралтын байр сууцны нөхцөл байдлаас шалтгаалаад амрагчдын тоо буурах хандлагатай болжээ.

“Горхи мэлхий хад” УТҮГ нь 2017 онд 2000 хүнд амралтын үйлчилгээ үзүүлсэн нь 2016 онтой харьцуулбал 42.8 хувиар буюу 1500 хүнээр буурсан байна.

Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 183 дугаар тогтоолоор тус амралтын газрыг дуудлага худалдаагаар худалдах, Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны 2014 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 4/2190 тоот албан бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж зарагдах хүртэл хөрөнгийн хөдөлгөөн хийхгүй хамгаалж, хадгалах чиглэл өгч байсан байна.


Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/282 дугаар тушаалаар тус амралтын газрын үйл ажиллагааг түр зогсоохоор шийдвэрлэж, харуул хамгаалалт болон бусад үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Гаалийн ерөнхий газрын Үйлчилгээ, аж ахуйн албаны төсвөөс санхүүжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан байна.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бээвэр санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй



нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 15 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ нь “Ординат” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програмыг санхүүгийн үйл ажиллагаандаа хэрэглэж, санхүүгийн тайлан, мэдээллийг боловсруулсан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Орлого, зардал, санхүүгийн тайлангийн талаарх тайлбар, тодруулга

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ нь өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг байна.

Тайлант онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1.5 сая төгрөг байсан бөгөөд үндсэн үйл ажиллагаанаас 58.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, Гаалийн ерөнхий газраас 6.6 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт 65.3 сая төгрөгийн мөнгөн орлого төвлөрүүлэн 66.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулснаар оны эцэст 38.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/136 дугаар тушаалаар 0.8 сая, 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар 10.8 сая, нийт 11.6 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын балансаас тус УТҮГ-ын балансад шилжүүлж өгсөн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 заалт, Засгийн газрын 2017 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу байгууллагынхаа Shilendgn.mn

цахим хуудсанд 5,0 саяас дээш гүйлгээ, захирлын 2017 онд гарсан тушаал, шийдвэр зэрэг мэдээллүүдийг байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн хяналтыг хийхэд тус УТҮГ-ын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд зөрчилтэй асуудал илрээгүй болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй болно.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/282 дугаар тушаалаар тус УТҮГ-ын үйл ажиллагааг түр зогсоосон тухай асуудлыг судалж, цаашид тус амралтын эзэмшлийн газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүрэн бүтэн байдлыг хэрхэн хангах, тэдгээрийн санхүүгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний бодлого боловсруулсан эсэх, түүний хэрэгжилт, үр дүнг хянах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зөрчил илрээгүй.


2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ҮАГ-ын захиалгаар “Нью дийл аудит” ХХК аудитыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар бараа материалын жилийн эцсийн бүртгэлээр хөрөнгийн чанартай 9 нэр төрлийн 1.3 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх зөвлөмж өгсөнөөс 0.6 сая төгрөгийн 3 нэр төрлийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр залруулж бүртгэсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны орлого дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 78.5 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажуулав.



2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.




3 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,555,250.00	38,953.02
Дансны авлага		
Ажилчдаас авах авлага		
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	12,365,732.00	11,580,310.00
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Эргэлтийн хөрөнгийн дүн	13,920,982.00	11,619,263.02
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	433,449,701.04	422,443,314.88
Биет бус хөрөнгө	168,750.00	56,250.00
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	433,618,451.04	422,499,564.88
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	447,539,433.04	434,118,827.90
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	28,902,175.79	22,930,712.00
Цалингийн өглөг		
Татварын өр	968,079.33	
ЭМД-ийн өглөг	234,837.41	
Бусад өглөг		
Хүүний өглөг		
Урьдчилж орсон орлого		
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	30,105,092.53	22,930,712.00
Бусад урт хугацаат өр төлбөр		



Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн нийт дүн	30,105,092.53	22,930,712.00
Эздийн өмч		
Өмч:- төрийн	642,361,589.25	642,361,589.25
- хувийн		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	75,465,150.00	75,465,150.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эзэмшигчдын өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(300,392,398.74)	(306,638,623.35)
Эздийн өмчийн дүн	417,434,340.51	411,188,115.90
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	447,539,433.04	434,118,827.90



3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого	79,710,300.00	58,698,900.00
Борлуулалтын өртөг		
Нийт ашиг (алдагдал)	79,710,300.00	58,698,900.00
Түрээсийн орлого		
Хүүний орлого		
Ногдол ашгийн орлого		
Татаас санхүүжилтын орлого	3,959,000.00	6,594,700.00
Бусад орлого		13,169,500.00
Борлуулалт маркетингийн зардал	103,442,764.77	87,209,499.61
Ерөнхий ба удирдлагын зардал		
Санхүүгийн зардал		
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(19,773,464.77)	(8,746,399.61)
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	(19,773,464.77)	(8,746,399.61)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(19,773,464.77)	(8,746,399.61)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	(19,773,464.77)	(8,746,399.61)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



3.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн				
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	642,361,589.25	75,465,150.00	(300,392,398.74)	417,434,340.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,500,175.00	2,500,175.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн			(8,746,399.61)	(8,746,399.61)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	642,361,589.25	75,465,150.00	(306,638,623.35)	411,188,115.90



3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮНДСЭН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	79,710,300.00	65,293,600.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	79,710,300.00	58,698,900.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Татаас санхүүжилтийн орлого		6,594,700.00
Бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн (-)	78,160,637.80	66,809,896.98
Ажиллагчдад төлсөн	38,838,364.80	31,566,705.07
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,039,000.00	2,845,292.91
Бараа материал худалдан авахад төлсөн	14,279,470.00	11,728,710.00
Ашиглалтын зардалд төлсөн	16,479,710.00	16,885,700.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	3,524,093.00	3,783,489.00
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	1,549,662.20	(1,516,296.98)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
Улсын төсвийн хөрөнгө оруулалт		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн өөрийн хөрөнгө		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)		-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Бусад орлого		



Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Бусад зарлага		
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,549,662.20	(1,516,296.98)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,587.80	1,555,250.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,555,250.00	38,953.02



3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Санхүүжилтийн орлого		6,594,700.0	6,594,700.0
Үндсэн үйл ажиллагааны орлого		57,790,900.0	57,790,900.0
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		908,000.0	908,000.0
Балансаас балансад шилжиж ирсэн орлого		13,169,500.0	13,169,500.0
Нэг удаагийн шагнал урамшуулал			-
ОРЛОГЫН ДҮН	-	78,463,100.0	78,463,100.0
Үндсэн болон нэмэгдэл цалин		28,845,578.8	28,845,578.8
НДШимтгэл		3,192,213.7	3,192,213.7
Нэг удаагийн шагнал урамшуулал			-
Дулааны зардал			-
Бичиг хэргийн		64,100.0	64,100.0
Банкны шимтгэл		83,731.0	83,731.0
Гэрэл цахилгааны зардал		5,525,700.0	5,525,700.0
Түлш, халаалтын зардал		8,000,000.0	8,000,000.0
Цэвэр, бохир усны зардал		1,760,000.0	1,760,000.0
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		88,100.0	88,100.0
Шуудан холбооны зардал			-
Дотоод томилолтын зардал			-
Цэвэрлэгээ хог хаягдлын зардал		328,000.0	328,000.0
Буфетны бараа		2,130,390.0	2,130,390.0
Багаж хэрэгслийн зардал		1,076,434.0	1,076,434.0
Хөдөлмөр хамгаалал		489,610.0	489,610.0
Зар сурталчилгаа			-
Бараа үйлчилгээний бусад зардал		1,486,400.0	1,486,400.0
Тээврийн зардал		714,000.0	714,000.0
Засварын зардал		604,380.0	604,380.0
ҮХЭ зардал		23,383,386.2	23,383,386.2
Газрын татвар			-
ҮХХ-ийн татвар			-
Тээврийн хэрэгслэлийн татвар, даатгал			-
Төрийн байгууллага ажилтаны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөр		1,000,000.0	1,000,000.0
Үйлчилгээ ба гэрээт ажлын			

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

хөлс			
Тоног төхөөрөмж, тавилга авах			-
Автомашин худалдан авах			-
Хоолны зардал		6,424,118.0	6,424,118.0
Аудитын зардал		1,500,000.0	1,500,000.0
Суудлын бүрээс			-
Түрээсийн зардал			-
Нийслэл хотын татвар		513,358.0	513,358.0
ЗАРДЛЫН ДҮН	-	87,209,499.6	87,209,499.6
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	-	(8,746,399.6)	8,746,399.6
Татварын зардал			-
Цэвэр ашиг алдагдал	-	(8,746,399.6)	8,746,399.6

